



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны А/05 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “1 дүгээр хорооны 2 дугаар байр, 2 дугаар хорооны 7 дугаар байрны дээврийн засварын ажлын зураг төсөв” болон “Хороо хоорондын авто замын засварын ажлын зураг төсөв”-г боловсруулах үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

Ахлагч: Д.Хүрэлбаатар

Засаг даргын Тамгын газрын
Тохижилт, худалдаа үйлчилгээний
хэлтсийн дарга

Гишүүд: Б.Хишиг-Ундрал

Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ын
инженер

Г.Батням

Багахангайн Үйлдвэрлэл технологийн
паркийн Нягтлан бодогч

С.Өлзийсайхан

1 дүгээр хорооны иргэн

Нарийн бичиг:

Э.Урансайхан

Худалдан авах ажиллагааны албаны
худалдан авах ажиллагаа хариуцсан
мэргэжилтэн

2. Хууль, тогтоомжийн дагуу үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Ажлын хэсэг (Д.Хүрэлбаатар)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД